Санхүүгийн хяналт шалгалт
хийсэн дүнгийн тухай.

НЭГ: ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО.

Тус албаны 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг улсын болон орон нутгийн төсөвт автомашин, автограж бүхий байгууллагуудын автомашин, автограж ашиглалтын үйл ажиллагаа нь "Төсвийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулиуд болон Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 184 дүгээр тогтоол, "Албан ажлын болон албан тушаалтны автомашины хэрэглээний хязгаар тогтоох тухай" аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/126, "Орон нутгийн өмчит байгууллагуудын автомашинд наалт хэрэглэх тухай" 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/503 дугаар захирамжуудад нийцэж байгаа эсэхийг "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн дагуу шалгаж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж, засаж залруулан, зөвлөн тусалж, ирээдүйд учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хяналт шалгалтын зорилго оршино.

ХОЁР: ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА.

Шалгалтыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга, СХШ-ын Улсын ахлах байцаагч Д.Ганзориг ахалж, СХШ-ын Улсын байцаагч Ц.Баттөр, А.Бүрэндэлгэр, ОНӨГ-ын мэргэжилтэн Р.Пүрэвдорж, З.Мөнхнасан, Б.Балдорж нарын бүрэлдэхүүнтэйгээр 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс ажлын 10 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэв.

Тус шалгалтын танилцуулга, захиргааны актын төслийг 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдөр аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж хэлэлцүүллээ.

ГУРАВ: ШАЛГАЛТАД ХАМРАГДСАН АСУУДЛУУД.

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг улсын болон орон нутгийн төсөвт автомашин, автограж бүхий байгууллагуудын автомашин, автограж ашиглалтын үйл ажиллагаатай танилцаж, хувь хүний өмчлөлийн автомашин гражид тавьсан эсэх, хоногийн төлбөр, түүний төвлөрүүлэлтэд хяналт хийв.

ДӨРӨВ: ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.

Өмнө нь энэ чиглэлээр хяналт, шалгалт хийж байгаагүй болно.

ТАВ: ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДЛУУД.

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт судалгаа ирүүлэх тухай албан бичгийг хавсралт хүснэгтийн хамтаар хүргүүлж, автомашины судалгаанд суурилсан хяналтыг хийв.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг төсөвт байгууллагууд, төрийн өмчит ААН-үүдээр явж, эрх бүхий албан тушаалтнуудад удирдамжийг танилцуулан, автомашин, автогражтай танилцаж, наалт наасан эсэхэд хяналт хийж, наалт хэрэглэх тухай чиглэл өгөв.

Аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох зорилгоор зарын нэгдсэн группэд Албаны автомашиныг хувийн хэрэгцээнд ашиглаж байгаа тухай баримттай мэдээллийг 70481111 дугаараар хүлээн авах тухай нийтэд мэдээлсэн болно.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3 дугаар байр, Татварын хэлтэс, “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар” -ын автогражид хувийн автомашин тавьсан байлаа.

Эдгээр байгууллагуудын жижүүрийн дэвтэртэй танилцаж, гражид машин тавьсан хугацааг түүж ажиллалаа.

Шалгалтын явцад зарим нэгэн байгууллагын автомашинд ОНӨГ-аас наалт олгов.

СХАА-ны цахим хуудсаар дамжуулан аймгийн нэгдсэн зарын группэд албан хэрэглээний автомашинтай холбоотой гарсан захирамжуудын талаарх мэдээллийг нийтэд хүргэж ажиллалаа.

ЗУРГАА: ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, **ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ.**

1. Наалтыг наасан боловч дараах байгууллагууд буцааж хуулсан байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газарт ашиглаж буй /4489УБҮ/, Мэргэжлийн хяналтын газар /6354ГАҮ/ , Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар /8458ГАҮ/.

Энэхүү үйлдэл нь *“Орон нутгийн өмчит байгууллагуудын автомашинд наалт хэрэглэх тухай” 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/503 дугаар захирамжийн 2/.....наалтыг байнга хэрэглэж хэвших, автомашины шатахуун зарцуулалтыг бууруулж, төсвийн хэмнэлт гаргаж ажиллахыг төрийн байгууллагуудын удирдлага (дарга, захирал, эрхлэгч)-д тус тус үүрэг болгосугай./-т заасныг*

2. Доорх байгууллагуудын автомашинд наалт наагаагүй байна. Хүснэгт 1-ээр харуулав. Үүнд:

/хүснэгт-1/

д/д	Байгууллагын нэр	Авто машины тоо	Улсын бүртгэлийн дугаар
1	Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар	1	1009 ГАҮ
2	Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар	1	6000ГАА

3	Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар	1	1153ГАҮ
4	Есөнбулаг сумын ИТХ	1	0031ГАҮ
5	Аймгийн ИТХ-ын ажлын алба	1	00-02 ГАҮ

Энэ үйлдэл нь *“Орон нутгийн өмчит байгууллагуудын автомашинд наалт хэрэглэх тухай” 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/503 дугаар захирамжийг*

3. Дараах байгууллагууд автомашиндаа наалт аваагүй байна. Хүснэгт 2-оор харуулав. Үүнд:

/хүснэгт-2/

д/д	Регистрийн дугаар	Сум	Хуулийн этгээдийн нэр	Авсан наалтын тоо
1	-	Есөнбулаг	Аудитын газар	2
2	9016376	Баянтоорой	Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын алба	1
3	9015493	Гуулин	Гуулин тосгоны Захирагчийн ажлын алба	1
4	9017445	Хөхморьт	Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар	2

Энэ үйлдэл нь *“Орон нутгийн өмчит байгууллагуудын автомашинд наалт хэрэглэх тухай” 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/503 дугаар захирамжийг*

4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3 дугаар байрны дулаан гражид хувь хүний өмчлөлийн дараах автомашинуудыг төлбөргүйгээр, урт хугацаанд тавиулсан байна. Хүснэгтээр харуулав.

/хүснэгт-3/

д/д	Автомашин эзэмшигч	Гражид байрлуулсан хугацаа	Нийт хоног	Автамашины дугаар
1	Д.Баттайван	2019.10.06-2019.10.17 2019.11.08-2020.02.05	69	3082УНТ
2	Б.Алтайбаатар	2019.11.13-2020.02.05	53	2866ГАҮ

Энэхүү үйлдэл нь “Түрээсийн төлбөрийн доод үнэ, гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 68 дугаар тогтоолын

2-г/Орон нутгийн өмчийн хуулийн этгээд Нийтлэг үйлчилгээ орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын 1, 2, 3 дугаар байрны түрээс болон бусад орлогоор Нийтлэг үйлчилгээ орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын урсгал зардлыг санхүүжүүлэх/ -д зааснаг тус тус зөрчсөн байна.

ДОЛОО: ДҮГНЭЛТ.

Ажлын хэсгийг байгууллагуудаар ажиллах үед наалтыг наасан боловч буцааж хуулсан сөрөг үзэгдэл гарсан, нэн яаралтай наахаар үүрэг хүлээсэн боловч наагаагүй зэрэг

зөрчлүүд нь аймгийн Засаг даргын захирамж, шалгалтын бүрэлдэхүүний шаардлагыг үл хүндэтгэсэн, ёс зүйгүй үйлдэл гэж шалгалтын бүрэлдэхүүний зүгээс дүгнэж байна.

, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 9 дүгээр тогтоолын 4 дэх хэсэгт тусгасан Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагууд болон аймгийн ЗДТГ, Есөнбулаг сумын ЗДТГ, “Ундарга-Алтай” ОНӨАТҮГ-т 2 заалт бүхий хугацаантай албан шаардлагыг тус тус хүргүүлэв.

НАЙМ: ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ.

1. Тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төсөвт болон төрийн өмчит ААН, байгууллагууд автомашиндаа ялгах тэмдэг наалтыг заавал хэрэглэх.

2. Албан бус хэрэгцээнд автомашин ашиглахгүй байх.

3. Албан ажлын хэрэгцээний автомашиныг хувийн зориулалтаар ашиглаж байгаа талаарх баримттай мэдээллийг ард иргэдээс 70481111 утсаар хүлээн авах тухай зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд таниулах.

4. Дулаан граж бүхий байгууллагын сул талбайд автомашин тавиулж орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлэх.

5. Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.

Илэрсэн зөрчлүүдийг цаашид таслан зогсоож, шалгалтын танилцуулгаар өгсөн үүргийг бүрэн хангуулж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөж байна.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА Д.ГАНЗОРИГ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ: А.БҮРЭНДЭЛГЭР

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ: Ц.БАТТӨР

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН З. МӨНХНАСАН

Р.ПҮРЭВДОРЖ